



49

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 29

Номгон

Г

Г

**Албан тушаалын сул орон тоонд
нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4, 5 дугаар зүйлийн 5.7, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэ оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан Төрийн захиргааны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул ажлын байрыг нөхөх тусгай шалгалтын тайланг хянан үзээд сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан П.Болормааг Нийгмийн даатгалын газрын тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн даргаар, Р.Бодьсайханыг Захиргаа хяналтын хэлтсийн даргаар, М.Чанцалдуламыг Баян-Овоо сумын нийгмийн даатгалын байцаагчаар, У.Амарбаясгаланг Баян-Өндөр сумын нийгмийн даатгалын байцаагчаар, Б.Цэдэвсүрэнг Санхүү бүртгэл хариуцсан мэргэжилтнээр, Б.Цэвээнсүрэнг Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Б.Отгонцэцэгийг Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Баянбулаг сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Н.Мөнхгэрэлийг Баянлиг сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Л.Вандандоржийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнээр, Б.Лхаасүрэнг Нийгмийн бодлогын хэлтсийн соёл урлаг, спортын салбарын асуудал хариуцсан мэргэжилтнээр, Т.Оюунгэрэлийг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнээр, Ц.Баасанбатыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Г.Лхагва-Очирыг Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтсийн даргаар, Г.Дүүрэнбилэгийг Заг сумын Санхүү албаны даргаар, Т.Номинчимэгийг Баянхонгор

- 642213183

сумын Цахир 7 дугаар багийн зохион байгуулагчаар тус тус томилуулахаар нэрийг дэвшүүлсүгэй.

2. Төрийн албаны тусгай шалгалтад хамгийн өндөр оноо авч сул ажлын байранд нэр дэвшигдсэн иргэдийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 22.1.3, 22.1.5-д тавигдсан шаардлагыг хангаж байгаа баримтыг холбогдох байгууллагаас авч хянахыг холбогдох байгууллагын дарга нарт сануулсугай.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг чанд сахиж, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчилгүй ажиллахыг тухайн албан тушаалд нэр дэвшигчдэд зөвлөсүгэй.

